

“Үгчлэх утгачлах, идээшүүлэх ондоошуулахын” шүтэлцээ

М.Чимэдцэеэ /МУИС, ГХСС/

Товч агуулга: *Нэгэн соёлын дотор орших ер энгийн зүйлийг өөр нэгэн соёлд ихээхэн хүч ухаан зарж тайлбарлах, дамжуулах явдал орчуулах, дуун хөрвүүлэх хэрэгт алхам тутам тааралддаг. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстэн угсаатны соёлын ухагдахууныг орчуулж дамжуулахдаа уншигч хүнд ойлгомжтой байхыг чухалчлах уу, эсбөгөөс эх бичвэрт үнэнч байхыг чухалчлах уу гэсэн асуулт зүй ёсоор урган гардаг.*

Соёлын орчуулга судлалын үндсэн стратеги хэмээгддэг “идээшүүлэх” (domestication, доместикация, 归化) ба “ондоошуулах” (foreignization, форенизация, 异化) нь чухам эндээс эх үүдэлтэй юм.

Үгчлэх, утгачлахыг орчуулгын үндсэн арга ухаан хэмээн үздэг бол, идээшүүлэх, ондоошуулахыг орчуулгын үндсэн бодлого стратеги хэмээн үздэг.

Орчуулахуйн ухааны “үгчлэх-утгачлах, идээшүүлэх-ондоошуулах” хэмээсэн энэхүү хосмолжин ухагдахуун нь хос хосоороо харилцан сүлэлдсэн, харилцан эсрэгцсэн, бас харилцан давхцсан нэр томъёонууд юм.

Идээшүүлэх, ондоошуулах нь соёлын хүчин зүйлийг онцлон, үндэстэн хоорондын соёлын харилцаа хамаарлыг чухалчлан үздэг бол үгчлэх, утгачлах нь хэлний давхарга бүтцийг чухалчилдаг ажгуу.

Үгчлэх, утгачлах нь хоёр өөр хэлний өөр өөр бүтэц, онцлог, хэлбэр хийгээд агуулгын холбоо хамаарлыг чухалчлан үздэг бол идээшүүлэх, ондоошуулах нь хэлний бүтэц давхаргад илрэхээс гадна соёлын гүн чанад давхаргад илэрч гардаг байна. Үгчлэх, утгачлах нь орчуулгын уран чадвар, арга барилын хамааралтай асуудал бол идээшүүлэх ондоошуулах нь орчуулахуйн стратеги бодлого лугаа хамааралтай асуудал юм.

Түлхүүр үг: *соёлын орчуулга судлал, соёлын ялгаа, үгчлэх, утгачлах, идээшүүлэх, ондоошуулах*

Үндэстэн угсаатны соёлын ялгаа зөрөөг хэрхэн зөв оновчтой илэрхийлж орчуулах суудал эдүгээ хэл шинжлэл, орчуулга судлал, гүн ухаан, соёл судлал зэрэг олон ухааны холбоо хамаарал бүхий тулгам чухал сэдэв болоод байна.

Орчуулах, дуун хөрвүүлэх ажилд аливаа нэг үндэстэн угсаатны соёлын ялгаа зөрөөг дамжуулж илэрхийлэхдээ орчуулгын нэгэнт тогтож хэвшсэн хэв загварт хийгээд уламжлалт орчуулгын арга ухааныг хатуу баримтлан, утга санаа дүйх үг хэллэгээр шууд

дүйлгэн орлуулах бус, харин тухайн соёлын учир холбогдол, гарвал түүх, ялгаа зөрөө, өвөрмөц онцлог зэргийг тал талаас нь тунгаан нягталж, хамгийн оновчтой илэрхийлэх нь туйлын чухал болохыг эрдэмтэн судлаачид онцлон тэмдэглэж, шинэ үзэл онол дэвшүүлж байна.

Тийнхүү орчуулга судлал нь зөвхөн хэлшинжлэл төдийгүй, шинжлэх ухааны бусад олон салаа салбар лугаа улам бүр холбоо хамаарал бүхий болж, орчуулгазүйн хөгжлийн шинэ чиг хандлага бүрэлдэн буй болж дэлгэрч байна. Тийм харьцангуй шинэхэн салбар бол СОЁЛЫН ОРЧУУЛГА СУДЛАЛ юм. Хэл шинжлэл, соёл судлал, хэлний соёл судлал, гүн ухаан, орчуулгазүй зэрэг олон ухааны уулзвар зааг дээр үүсэн буй болж, хөгжиж буй шинэхэн салбар ухааныг СОЁЛЫН ОРЧУУЛГА хэмээн нэрлэж байна. Соёлыг тээгч нь болох ХЭЛ, хэлээр дамжин илэрлэг СЭТГЭЛГЭЭ, СОЁЛ, үндэстний соёлыг өртөөлөгч нь болох ОРЧУУЛГА гурвын өвөр хоорондын гадаад холбоо шүтэлцээ, дотоод зүй тогтлыг судалдаг ухааныг СОЁЛЫН ОРЧУУЛГА СУДЛАЛ хэмээн томъёолж байна.

Орчуулахуйн ухааны уламжлалт үндсэн хоёр арга болвоос үгчлэх (直译), утгачлах (意译) билээ. Монгол орчуулгын онолын чиг баримжаа, жаяг зарчмыг тодорхойлсон “Мэргэд гарахын орон” зохиолд “яруу найртай”, “утга төгс”, “мэдэхүйеэ хялбар” хэмээх орчуулгын онолын үндсэн 3 зарчим, чиг баримжааг чухалчлан дурдаж, монголын төдийгүй, дэлхий нийтийн орчуулгын нийтлэг нэгэн баримтлал болох “үг үсгийг бус утга санааг шүтэн” орчуулах ёс зарчмыг тов тодорхой томъёолон заасан байдаг.

Эрдэмтэн дуун хөрвүүлэгч, соён гэгээрүүлэгч Г. Акимын тэмдэглэсэнчлэн “Дэлхийд одоо баримталж байгаа онолын бараг бүх зарчмыг 200 гаруй жилийн өмнө бидэнд хэлээд өгсөн” байдаг.

Монголын билигт дуун хөрвүүлэгч мэргэд яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар хэмээх орчуулгын энэхүү үндсэн гурван зарчмыг томъёолсоноос хойш даруй 160 гаруй жилийн хойно, Хятадын соён гэгээрүүлэгч, орчуулагч Ян Фу (严复 1853-1921) “шударгуу үнэн”, “ойлгомжтой тод”, “яруу сайхан” гэсэн орчуулгын гурван зарчмыг анх дэвшүүлж, “Орчуулахуйн гурван бэрх: шин, да, я” (译事三难: 信,达,雅) хэмээх хятад орчуулгын үндсэн гурван чиг баримжааг анх томъёолсон нь эдүгээ хятадын орчуулгын онолын үндсэн жаяг зарчим болсоор байна.

Нэгэн соёлын дотор орших ер энгийн зүйлийг өөр нэгэн соёлд ихээхэн хүч ухаан зарж тайлбарлах, дамжуулах явдал орчуулах, дуун хөрвүүлэх хэрэгт алхам тутам тааралддаг. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстэн угсаатны соёлын ухагдахууныг орчуулж дамжуулахдаа уншигч хүнд ойлгомжтой байхыг чухалчлах уу, эсбөгөөс эх бичвэрт үнэнч байхыг чухалчлах уу гэсэн асуулт зүй ёсоор урган гардаг.

Соёлын орчуулга судлалын үндсэн стратеги хэмээгддэг “идээшүүлэх” (**domestication, доместикация, 归化**) ба “ондоошуулах” (**foreignization, форенизация, 异化**) нь чухам эндээс эх үүдэлтэй юм.

Үгчлэх, утгачлахыг орчуулгын үндсэн арга ухаан хэмээн үздэг бол, идээшүүлэх, ондоошуулахыг орчуулгын үндсэн бодлого стратеги хэмээн үздэг.

Америкийн орчуулгын онолч Лоренс Венути-гийн (**Lawrence Venuti**) дурдсанаар, “ИДЭЭШҮҮЛЭХ гэдэг нь өөрийн үндэснийхээ соёлыг гол цөм болгон, эх бичвэр дэхь харь үнэлэмжийг орчуулж буй хэлнийхээ соёлд шингээн, өөрийн хөрснөө нутагшуулахыг, ОНДООШУУЛАХ гэдэг нь эх бичвэрийг гол цөм болгон, эх бичвэрт буй хэл, соёлын ялгаа зөрөөг хэвээр хадгалан, харь соёлыг таниулж, ондоошуулах” явдал юм.

Соёлын орчуулга судлалын үүднээс үзэхүл, уншигч хүнд ойлгомжтой байхыг чухалчлаваас “идээшүүлэх”, эх бичвэрт үнэнч байхыг чухалчлаваас “ондоошуулах” хэрэгтэй болдог байна.

Эх бичвэр дэхь соёлыг “идээшүүлэх”-ийн тулд хэт дүйлгэн, утгачлан орчуулваас тухайн үндэстэн угсаатны сэтгэлгээ, соёлын гүн чанад утга агуулга, учир холбогдол бүдгэрэн, орхигдож гээгдэхэд хүргэх бөгөөд орчуулга бус, зохиол мэт болох гэмтэй байна. Энэ нь бидний дээр өгүүлсэн “ШУДАРГУУ ҮНЭН”, “УТГА ТӨГС” хэмээх зарчимд харшилна.

Эх бичвэр дэхь соёлыг “ондоошуулах”-ын тулд хэт тулган, үгчлэн орчуулваас тухайн үндэстэн угсаатны соёлын гүн чанад утгыг илтгэн чадах боловч, уншигч хүнд ойлгоход бэрхтэй болох гэмтэй байна. Энэ нь “МЭДЭХҮЙЕЭ ХЯЛБАР”, “ОЙЛГОМЖТОЙ ТОД” хэмээх зарчимд харшилна.

Үндэстэн угсаатан хоорондын соёлын ялгаа зөрөөг хэрхэн зөв илэрхийлж, зөв дамжуулах асуудлыг бид зарим нэг ажиглалт жишээн дээр, соёлын орчуулга судлалын “идээшүүлэх”, ондоошуулах”-ын үүднээс авч үзвэл илүү сонирхолтой байх буй заа.

Хятадын Тан улсын үеийн сод найрагч Ли Байн шүлгүүдээс орос хэлнээс Б.Явуухулан, Ч.Чимид нар, хятад хэлнээс Ц.Базаррагчаа, Я.Ганбаатар нар монголчлон орчуулсан билээ.

Уг шүлгийн хятад эх нь:

望庐山瀑布

日照香炉生紫烟

遥看瀑布挂前川。

飞流直下三千尺

疑是银河落九天。

Б.Явуухулан, Ч.Чимид нар орос хэлнээс орчуулсан нь:

Лушань уулан дахь хүрхрээг харахад

Алсын буурал униарын тэртээ

Улбар туяа татав.

Арсгар уулыг би ширгэж

Урт хүрхрээг сонирхов.

Үүлэрхэг өндрөөс буусан хүрхрээ

Уулын хөвчийг зүсчээ.

Үзтэл, **тэнгэрийн зүйдэл** дорогшоо

Унасан юм шиг сунажээ. []

Ц.Базаррагчаа хятад хэлнээс орчуулсан нь:

Лу уулын хүрхрээг ажиглахуйяа

Хүлс хадыг наран ээхүйеэ, манан суунаг татаж

Хүрхрээн усан **гурван мянган тохой өндрөөс**

Гол руу, шаагин шуугин, цэнхэртэн буухуй нь

Газар руу, **тэнгэрийн заадас** тэр чигээрээ унах мэт ээ[]

Энэхүү яруу сайхан орчуулгуудаас бидний сонирхох зүйл бол “урт”, **тэнгэрийн зүйдэл**”, **гурван мянган тохой**”, “**тэнгэрийн заадас**” гэсэн үг хэллэгүүд юм.

Монгол хэлний “Тэнгэрийн заадас”, “Тэнгэрийн оёдол” хэмээх ухагдахууныг өрнөдахинд орос, англи хэлнээ “Сүүн зам” (“Млечный Путь”, “Milky Way”) хэмээн нэрлэдэг, дорнодахинд хятад хэлнээ “Тэнгэрийн гол”, “Мөнгөн гол” (“天河”, “银河”) хэмээн нэрлэдэг. Тийнхүү өөр өөрөөр нэрлэдэг нь тухайн үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, таньсан танилт, үнэлэмж, үндэстний соёлын ялгаа зөрөөг илтгэх агаад тэрхүү ялгааг домог түүхээс нь эрж үзвэл тодорхой мэдэж болно.

Тийнхүү орос хэлний “сүүн зам”, хятад хэлний “мөнгөн гол”-ыг монгол хэлний утга тохирох үгээр шууд дүйлгэн, “тэнгэрийн зүйдэл”, “тэнгэрийн заадас” хэмээн утгачлан дуун хөрвүүлэх нь уламжлалт орчуулгын аргын үүднээс үзэхүл “мэдэхүйеэ хялбар”, “яруу найртай” байх жаяг зарчимд бүрнээ нийцэж байна.

Соёлын орчуулгын “идэшүүлэх” ондоошуулах-ын үүднээс үзэхүл, “идэшүүлэх”-ийн жишээ болж, тэгснээр тухайн үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, таньсан танилт, үндэстний соёлын ялгаа зөрөө бүдгэрэн, монгол уншигч тэрхүү өрнөдахины “сүүн зам”, дорнодахины “мөнгөн гол” хэмээхүйн соёлын гүн чанад утгыг олж мэдэхгүйд хүрэх ажээ.

Орос хэлнээс орчуулсан орчуулгад “гурван мянган тохой” гэсэн хэллэгийг “урт” гэсэн нэг л үгээр орчуулжээ. Хятадаас оросоор орчуулсныг үзвэл энэ үг бас алга байна. Магадгүй орос уншигч “тохой” гэсэн дорно дахины уртын хэмжээний ухагдахууныг ойлгоход бэрхтэй тул тийнхүү дөхөмчлөн орчуулсан байж болох. Тэгвэл хятад хэлнээс дуун хөрвүүлсэн орчуулгад уг хэллэгийг шууд үгчлэн “гурван мянган тохой өндөр” хэмээн буулгасан нь нэг талаар монгол ахуйд шууд буун, уншиж сонсоход илүү яруу сайхан найруулга болж, нөгөө талаар тухайн үндэстэний соёлыг хэвээр хадгалан, “ондоошуулах”-ын сонгодог жишээ болж чадсан байна.

Орчуулахуйн ухааны “үгчлэх-утгачлах, идэшүүлэх-ондоошуулах” хэмээсэн энэхүү хосмолжин ухагдахуун нь хос хосоороо харилцан сүлэлдсэн, харилцан эсрэгцсэн, бас харилцан давхцсан нэр томъёонууд юм.

Идэшүүлэх, ондоошуулах нь соёлын хүчин зүйлийг онцлон, үндэстэн хоорондын соёлын харилцаа хамаарлыг чухалчлан үздэг бол үгчлэх, утгачлах нь хэлний давхарга бүтцийг чухалчилдаг ажгуу.

Үгчлэх, утгачлах нь хоёр өөр хэлний өөр өөр бүтэц, онцлог, хэлбэр хийгээд агуулгын холбоо хамаарлыг чухалчлан үздэг бол идэшүүлэх, ондоошуулах нь хэлний бүтэц давхаргад илрэхээс гадна соёлын гүн чанад давхаргад илэрч гардаг байна. Үгчлэх, утгачлах нь орчуулгын уран чадвар, арга барилын хамааралтай асуудал бол идэшүүлэх ондоошуулах нь орчуулахуйн стратеги бодлого лугаа хамааралтай асуудал юм.

Үгчлэх, утгачлахын тухайд хэлний бүтэц, өнгөн давхарга хэмээх нэг л өнцгөөс авч үздэг бол идэшүүлэх, ондоошуулахын тухайд хэлний хэлбэр, соёлын агуулга хэмээх хоёр өнцгөөс авч үздэг ажээ.

Тоймлон өгүүлвээс үгчлэх нь орчуулагчаас зохиогч руу буюу эх бичвэр руу хандаж чиглэсэн ондоошуулсан орчуулга, утгачлах нь орчуулагчаас уншигч руу хандаж чиглэсэн идэшүүлсэн орчуулга болно.

Идэшүүлэх хийгээд утгачласнаар орчуулга ойлгомжтой болж, хүлээн авч орчуулж буй хэлний хэл зүйн хэв журамд нийцэж байдаг бол ондоошуулах хийгээд үгчилснээр орчуулга эх зохиолтойгоо дүйцэж, эх зохиолын хэлний хэв журамд нийцэж байдаг ажгуу.

Идэшүүлэх, ондоошуулах нь эсрэг тэсрэг нэгдлийн дунд зэрэгцэн оршиж харилцан нөхөлцөж байдаг, аль аль нь өөрийн давуу талтай бас дутмаг талтай ажээ.

Аливаа орчуулга дан ганц идээшүүлэх, эсбөгөөс дан ганц ондоошуулах аваас орчуулга биш болж хувирах ажээ. Дан үгчилсэн буюу дан утгачилсан орчуулга гэж эс байхуйн нэгэн адил, дан идээшүүлсэн буюу дан ондоошуулсан орчуулга гэж үгүй. Үндэстэн дамнасан соёлын харилцааны байр сууринаас хандан, зохиолын төрөл зүйл, зохиогчийн санаа бодол, орчуулагчийн зорилго зорилт, уншигчийн хүрээ, шаардлага зэрэг олон талыг сайтар бодолцон байж, үгчлэх, утгачлах, идээшүүлэх, ондоошуулахыг дутуудаж дундрахгүй, хэтэрч халихгүй, чухам “тун хэмжээг” нь тэгш сайтар тэнцүүлэн үйлдвээс сая төгс сайн орчуулга төрөх учиртай юм.

结论

翻译是一种跨文化的信息交流与交换活动。异化和归化可以视为直译和意译的概念延伸，但又不完全等同于直译和意译。直译和意译所关注的核心问题是处理语言层面上的形式和意义，但异化和归化则打破了语言因素的局限，将范围伸展到语言，文化等多方面的因素。

НОМ ЗҮЙ

1. Мэргэд гарахын орон Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо., 1982
2. Лодойдамба.Ч “Тунгалаг тамир” УБ., 1971
3. Баянсан.Г. “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ” УБ., 2002
4. “清澈的塔米尔河” 温中和译 内蒙古人民出版社 1985 (Лодойдамба.Ч “Тунгалаг тамир” номын хятад орчуулга)
5. 文化翻译学 南开大学出版社 2007
6. 文化与翻译 中国社会科学出版社 2010
7. Ганбаатар.Я. Нангиадын сонгодог уран зохиол. УБ., 1998.
8. Явуухулан.Б, Чимид.Ч. Ли Бо. Шүлгүүд. УБ., 1960.